

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД 2022, 2023 ОНД ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ
ЗОРИУЛАЛТААР ОЛГОСОН ГАЗРЫН 50 ХУВИЙГ АШИГЛААГҮЙ БАЙНА”**

АУДИТЫН КОД: ХӨА-2024/30-7-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 86479090 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Г.Ичинхорлоо

Аудитор

С.Гансүх

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 11 дүгээр сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал, хавсралт

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйгээс газар төлөвлөлтийг үр дүнтэй хийх боломжийг бууруулж байна.

1.1. Аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйгээс газар төлөвлөлтийг үр дүнтэй хийх боломжийг бууруулж байна.

1.2. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг хийхдээ холбогдох хууль журмыг баримталж ажиллаагүй байна.

Бүлэг 2. Иргэн хуулийн этгээдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаагүй байна.

2.1 Иргэн хуулийн этгээдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаагүй байна.

2.2 Газрын төлбөрийн орлогыг бүрэн ногдуулахгүй байгаагаас 29.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн тайлбар

МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХӨА	Хөвсгөл аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/34

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, МУЕА-ын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар, Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Ганзориг, Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Жанлав, Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга З.Ням-Очир, Хатгал тосгоны Захирагч А.Баттүшиг нарт тус тус хүргүүлсүгэй.
3. “Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Ичинхорлоо)-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.
6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Г.Ичинхорлоо)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн
А/39 дүгээр тушаалын хоёрдугаар
хавсралт

“Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө”
гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	96/A2270648/ХӨА-2024/30-7-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
2	97/A2270648/ХӨА-2024/30-7-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
3	98/A2270648/ХӨА-2024/30-7-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай

оОо



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 05 өдөр

№ 96/А 2270641/ХӨА - 2024/
30-7-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө” гүйцэтгэлийн дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/26 дугаар захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 59 иргэнд газар олгосноос 24 иргэн огт ашиглаагүй, 2022 оны А/156 дугаар захирамжаар 33 иргэнд газар олгосноос 20 иргэн огт ашиглаагүй байна. /Сумын Засаг даргын захирамжаар олгосон ашиглаагүй газрын жагсаалтыг хавсаргаа/

Энэ нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн “40.1.6. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй 44 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹ т ирүүлэх.

2. Цаашид газрыг зориулалтын дагуу эзэмшиж буй эсэхэд хяналт хэрэгжүүлж, зөрчлийг тухай бүр арилгаж ажиллахыг Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга З.Ням-Очир, Хатгал тосгоны захирагч А.Баттүшиг, Хатгал тосгоны газрын даамал Ч.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОРА.ЭРДЭНЭБААТАР
ГИЧИНХОРЛОО

6724030345

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 11
дүгээр сарын 05-ны өдрийн
96/А2270640/ХӨА-2024/30-7-ШТА-ГА
тоот албан шаардлагын хавсралт

Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар олгосон ашиглаагүй газрын жагсаалт

№	Овог	Нэр	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ
Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/26 дугаар захирамж				
1	Алтанхүү	Эрдэнэбат	6714003292	700
2	Сүхээ	Батмөнх	6714003298	700
3	Нямдорж	Лхагвабаяр	6714003299	700
4	Нямдорж	Батсайхан	6714003300	700
5	Гансүх	Аажаргал	6714003302	700
6	Баттүшиг	Ганзориг	6714003304	700
7	Данзанпэрэнлэй	Золбоо	6714003305	700
8	Лхагвадаваа	Алтанцэцэг	6714003307	700
9	Батбаяр	Эрдэнэсүвд	6714003398	700
10	Маамаа	Янжмаа	6714003402	700
11	Баярсайхан	Болормаа	6714003403	700
12	Эрдэнэдаваа	Үүрийнцолмон	6714003404	700
13	Билэгдэмбэрэл	Далайбаатар	6714003505	700
14	Чойдорж	Ганзоригт	6714003409	700
15	Чулуунбаатар	Өлзийбат	6714003411	700
16	Нямчулуун	Онон	6714003413	700
17	Даваасамбуу	Гал-Эрдэнэ	6714003415	700
18	Дорж	Гүндэгмаа	6714003417	700
19	Дана	Пүрэвдорж	6714003418	700
20	Пүрэв	Эрдэнэчимэг	6714003310	700
21	Мөнхчулуун	Баярмаа	6714003320	700
22	Сүхбаатар	Маралмаа	6714003311	700
23	Өнөртүвшин	Батбаяр	6714003319	700
24	Пүрэвсүрэн	Мягмардалай	6714003317	680
Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/156 дугаар захирамж				
25	Төмөр	Батмөнх	6714003612	700
26	Энэбиш	Лхагвабаяр	6714003614	700
27	Нордов	Даваасүрэн	6714003615	700
28	Бадамжунай	Бат-Өлзий	6714003616	700
29	Энхтайван	Нямсайхан	6714003618	700
30	Пүрэвсүрэн	Ууганбаяр	6714003919	700
31	Пүрэвжав	Наранцэцэг	6714003621	700
32	Төмөр	Батболд	6714003623	700
33	Гал-Эрдэнэ	Мөнхцэцэг	6714003624	700
34	Даш	Төмөр	6714003625	700
35	Данзанпэрэнлэй	Энхбаяр	6714003626	700
36	Нармандах	Нямбат	6714003627	700
37	Батжаргал	Отгондалай	6714003628	700
38	Жорх	Оюундалай	6714003629	700
39	Ганбаатар	Ням-Эрдэнэ	6714003636	700
40	Ганбат	Сэржмаа	6714003605	700
41	Ганбаатар	Ганбаяр	6714003607	700
42	Шинэбаяр	Отгонбаяр	6714003608	700
43	Лхагвадорж	Эрдэнэсүвд	6714003610	700
44	Хашбат	Энхбаяр	6714003633	700

оОо



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 05 өдөр

№ 97/А2270648/ХӨА-2024/
30-7-ШТА-1А

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны захирагч, ажлын албаны зүгээс иргэн, аж ахуйн нэгжид олгосон газрыг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт хангалтгүй, тодорхой зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал:

1. Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны А/161 захирамжаар олгогдсон 6714003635, 6714003634, 6714003406 гэсэн нэгж талбарын дугаар бүхий 3 газарт хэмжилт хийхэд 700 м2-аас хэтрүүлэн хашааг барьсан,
2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон 6714003972 нэгж талбар бүхий газарт Леона амралтын газрын зориулалтаар ашигласан,
3. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон 6714300353 нэгж талбарт худалдаа, үйлчилгээний зориулалтаар ашигласан,
4. Худалдаа нийтийн үйлчилгээний зориулалтаар олгосон 6714002375, 6714001378 гэсэн нэгж талбаруудыг газар ашиглах гэрээ, гэрчилгээ, кадастрын зурагт заасан хэмжээнээс илүү хэмжээгээр, мөн усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зөрчиж хашаалсан байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 “Газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газар эзэмших гэрээ, гэрчилгээнд заасан талбайн хэмжээ, зориулалтын дагуу газрыг үр ашигтай ашиглаж байгаа зөрчилд хяналт хэрэгжүүлж, дээрх зөрчлүүдийг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар²т ирүүлэх,


6724070350

² Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

2. Цаашид газар олголтын мөрөөр хийгдэх хяналтыг сайжруулж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажиллахыг Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга З.Ням-Очир, Хатгал тосгоны захирагч А.Баттүшиг, Хатгал тосгоны газрын даамал Ч.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР
Г.ИЧИНХОРЛОО

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 05 өдөр

№ 98/АЭЭТ0641/ЗДА-2024/
30-7-ШТА-18

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алаг-Эрдэнэ сум нь газрын төлбөрийн орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, Хатгал тосгоны газрын төлбөрийн орлогыг нэгж талбарын хэмжээ, газрын төлбөрийн орлогод үндэслэн тооцож үзэхэд 2022 онд 6.6 сая төгрөг, 2023 онд 12.7 сая төгрөг, 2024 онд 10.4 сая төгрөг нийт 29.7 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогын ногдуулалтыг хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Газрын тухай хуулийн 23.4.5. “газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын төлбөрийн орлогыг нэгж талбарын судалгаанд үндэслэн төлөвлөж, системд ногдуулалтыг хийж, өмнөх оны төлбөрийг бүрэн төвлөрүүлж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар³т ирүүлэх,

2. Цаашид газрын төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлж ажиллахыг Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга З.Ням-Очир, Хатгал тосгоны захирагч А.Баттүшиг, Хатгал тосгоны газрын даамал Ч.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОРА.ЭРДЭНЭБААТАР
ГИЧИНХОРЛОО

6724030364

³ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаал, Монгол улсын Ерөнхий аудитортай байгуулсан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө”-д Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших ашиглах, эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх, өмнөх аудитаар төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдсан эсэхэд хяналт хийж дахин үнэлгээ дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үр нөлөөтэй байхаар тооцон төлөвлөж баталсан эсэх.
- Иргэн, аж ахуй нэгжид ашиглуулж эзэмшүүлэхээр олгосон газар нь үр нөлөөтэй, үр ашигтай эсэх.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж зөрчлийг арилгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны 2023-2024 оны газар зохион байгуулалтын үйл ажиллагаа, газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой, шийдвэрүүд хувийн хэрэг, баримт материал, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтүүдийг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитор С.Гансүх нар аудитын

төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.


Аудитад үүссэн хязгаарлалт:

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа нь аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн хуулийн хугацаатай давхацсанаас холбогдох зарим албан хаагчид тайлбар тодруулгыг хугацаанд өгч чадахгүй байх зэрэг нөхцөл байдлыг үүсгэсэн.

Ерөнхий мэдээлэл:

Хатгал тосгон нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд Алаг-Эрдэнэ сумын 6 дугаар багт харьяалагдаж байна.

Улсын Их Хурлын 2011 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны төвийн эдэлбэр газар нутаг болох 1470 га газар нутгийг байгалийн цогцолборт газрын хилийн заагаас чөлөөлсөн байна.



Үүнээс 2024 оны байдлаар 2029 нэгж талбарт 363 га газрыг хуульд заасан зориулалтын дагуу иргэн аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлж, 472 нэгж талбарын 62 га газрын иргэн, аж ахуйн нэгжүүдэд өмчлүүлсэн байна. Хатгал тосгоны газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөг Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 76 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан байна.

Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Хатгал тосгоны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны А/160 дугаартай захирамжаар 2 нэгж талбарт 30,505 м² талбайг төрийн байгууллагын эзэмшилд, А/161 дугаартай захирамжаар 53 нэгж талбарт 37,100 м² талбайг 53 иргэнд шинээр эзэмшүүлсэн бөгөөд 2024 онд газар эзэмшүүлэх шийдвэр гараагүй байна.

БҮЛЭГ 1:

Аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйгээс газар төлөвлөлтийг үр дүнтэй хийх боломжийг бууруулж байна.

1.1 Аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйгээс газар төлөвлөлтийг үр дүнтэй хийх боломжийг бууруулж байна.

1.1.1 Хөвсгөл аймгийн ихэнх сумд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөгүйгээс газрын төлөвлөлтийг системд оруулахгүй, газар олголт хийхгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

Газрын тухай хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

Хатгал тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2015 онд “Даблю эс эм эй” ХХК-аар хийлгүүлж, Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын тогтоолоор батлуулж, газар зохион байгуулалтын цахим системд оруулсан байна. Энэ төлөвлөгөө нь бодит байдалтай бүрэн нийцэхгүй, Хатгал тосгоны эдэлбэр газрыг нийтэд нь хамруулаагүй зөрчилтэй байна. **Тухайлбал:** гэр бүлийн зориулалттай олгосон газрыг аж үйлдвэрийн бүс гэж тусгасан, уурын зуухны байршлыг буруу тусгаснаас газрын нэгдсэн системд оруулж чадахгүй нөхцөл үүссэнээс 2024 онд шинээр баригдах уурын зуухны зураг, төсвийг хийлгэж чадаагүй зэрэг зөрчлүүд гарсан байна.

Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа талбар дээр хангалттай ажиллаагүй, нутгийн удирдлага, газрын даамалтай нарийвчлан зөвшилцөөгүй, Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулаагүй байна гэж үзэж байна. Энэ нь Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 “Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар аймаг, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний судалгааг авч үзэхэд Хөвсгөл аймгийн хувьд Ханх, Цэцэрлэг, Рашаант, Түнэл, Мөрөн сумаас бусад сумд нь төлөвлөгөөгүй байна. Үүнээс шалтгаалан 2024 онд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг системд оруулаагүйгээс шинээр газар олгох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

1.1.2. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь Хатгал тосгоны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний суурь болж чадахгүй байна.

Газрын тухай хуульд заасны дагуу сумын Засаг дарга нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Хатгал тосгоны 2022-2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Алаг-Эрдэнэ сумын ИТХ-аас баталсан байна.

Хүснэгт №1

№	Он	Шийдвэрийн огноо, дугаар
1	2022	Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны 22 дугаар тогтоол
2	2023	Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2022 оны 76 дугаар тогтоол
3	2024	Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2023 оны 04 дүгээр тогтоол

Хөвсгөл аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг “Газар дэлхий” ХХК боловсруулж, аймгийн ИТХ-ын 2015 оны 11 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолоор баталсан байна. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Хатгал тосгоны эдэлбэр

газрын газар зохион байгуулалтыг хэт ерөнхий байдлаар тусгасан, нийт талбайг бүхэлд нь хамруулаагүйгээс Хатгал тосгоны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний суурь болж чадахгүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 21.4 “Сумын Засаг дарга газрын харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 21.4.2. “аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийнхээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”, Монгол

Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 92 дугаар тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 3.25. “Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө дараах шаардлагыг хангасан байна”, 3.25.1. “улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын баримт бичиг, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд сумдын газар зохион байгуулалтыг хэт ерөнхий байдлаар тусгасан, нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө байхгүй нь газар зохион байгуулалтыг үр дүнтэй төлөвлөх боломжийг бууруулж байна.

1.2. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг хийхдээ холбогдох хууль журмыг баримталж ажиллаагүй байна.

1.2.1 Хатгал тосгоны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахдаа иргэн, аж ахуйн нэгжийн саналыг аваагүй байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын дагуу боловсруулна.

Хатгал тосгоны газар төлөвлөлтийг сүүлийн 3 жилийн байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сумын газрын даамал, Хатгал тосгоны захирагч боловсруулж Алаг-Эрдэнэ сумын Засаг даргад танилцуулсан.
2. Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын ИТХ-д өргөн мэдүүлсэн.
3. Сумын ИТХ-аас тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Журмын дагуу иргэн, аж ахуйн нэгжээс шинээр эзэмшиж, ашиглах газар болон өмнө нь эзэмшиж, ашиглаж байгаа газартаа газар зохион байгуулалт хийх хүсэлтийг хүлээн авч тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах ёстой. Дээрх дарааллаас харахад Хатгал тосгоны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа иргэн, аж ахуйн нэгжийн саналыг аваагүй байна. Энэ нь Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журмын 26 “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Засаг даргад ирүүлсэн хүсэлтийг аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал хүлээн аваад 14 хоногт багтаан судалгаа хийж санал, дүгнэлтээ Засаг даргад оруулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2.2. Аймаг, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд газрын нэгж талбарын төлөвлөлтийн дугаарыг тусгаагүй байна.

Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр, нэгж талбарын хуваарьтайгаар боловсруулна гэж заасан.

Хатгал тосгоны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд газрын зориулалтыг тусгасан боловч төлөвлөлтийн нэгж талбарын дугаарыг тавиагүй байна. Энэ нь Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Газар зохион байгуулалт хийх журмын 10 “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 25.3, 25.4 болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1-д заасан зарчим, үндэслэлийг

баримтлан газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр, нэгж талбарын хуваарьтайгаар боловсруулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг хийхдээ иргэн аж ахуйн нэгжээс санал авахгүйгээр боловсруулсан, төлөвлөлтийн нэгж талбарын дугаарыг тавихгүйгээр баталсан нь газрын зориулалт, нэгж талбар солигдох, талбайн хэмжээ өөрчлөгдөх эрсдэлийг дагуулж байна.

БҮЛЭГ 2:

Иргэн хуулийн этгээдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаагүй байна.

2.1. Иргэн хуулийн этгээдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаагүй байна.

2.1.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлын дагуу газар олголтыг хийсэн байна.

Хатгал тосгоны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталж, Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар газар олголт хийсэн байна. Хатгал тосгонд 2022, 2023 онуудад худалдаа үйлчилгээний зориулалтаар газар олгох төлөвлөгөө батлаагүй байна. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газар олголтын байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №2

№	Төлөвлөлтийн байдал		Олголтын байдал	
	ИТХ-ын шийдвэр	Газрын байршил хэмжээ	Захирамж	Олгосон байршил
1	Алаг-эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 6 дугаар хуралдааны 22 дугаар тогтоол	- Цахир хороонд 46 нэгж талбарт 32,200 м2 - Дэнж хороонд 37 нэгж талбарт 25,900 м2 - Нисэх, Цахир, Дэнж, Хөшөөт хороонд 9 нэгж талбарт 5,640 м2	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны 02 сарын 14-ний А/26 дугаар захирамж	- Дэнж хороонд 36 нэгж талбарт 24,680 м2 - Цахир хороонд 22 нэгж талбарт 15,400 м2 - Хөшөөт хороонд 1 нэгж талбарт 540 м2
2			Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/156 дугаар захирамж	- Цахир хороонд 26 нэгж талбарт 18,200 м2 - Дэнж хороонд 7 нэгж талбарт 4,900 м2
НИЙТ		63,740 м2		63,720 м2
3	Алаг-эрдэнэ сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 76 дугаар тогтоол	- Цахир хороонд 17 нэгж талбарт 11,900 м2 - Дэнж хороонд 14 нэгж талбарт 9,800 м2 - Хөшөөт хороонд 20 нэгж талбарт 14,000 м2 - Нисэх хороонд 2 нэгж талбарт 1,400 м2	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны А/161 дүгээр захирамж	- Цахир хороонд 17 нэгж талбарт 11,900 м2 - Дэнж хороонд 14 нэгж талбарт 9,800 м2 - Хөшөөт хороонд 20 нэгж талбарт 14,000 м2 - Нисэх хороонд 2 нэгж талбарт 1,400 м2
НИЙТ		37,100 м2		37,100 м2

Хүснэгтээс харахад Хатгал тосгонд 2022 онд 63,740 м² талбайд 92 нэгж талбарт, 2023 онд 37,100 м² талбайд 53 нэгж талбарт газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасан байршилд иргэдэд газар эзэмшүүлсэн байна. Харин хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйн улмаас 2024 онд иргэн, аж ахуйн нэгжид шинээр газар эзэмшүүлээгүй байна.

Газар зохион байгуулалтыг цахим системд нэвтрүүлснээр төлөвлөлтийн байршлаас өөр байршилд газар олгохгүй байх давуу талтай болсон байна.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын тогтоолоор худалдаа, үйлчилгээний зориулалтаар 2022 онд 396 м² газрыг нэг нэгж талбарт, 2023 онд 676 м² газрыг 2 нэгж талбарт тус тус дуудлага

худалдааг зохион байгуулсан байна. Дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж ажилласан боловч дуудлага худалдааны ялагч нь газрын үнийг төлөөгүй тул гэрээ хийж, газар эзэмших шийдвэр гараагүй байна.

2.1.2 Газрын төлөвлөлт, олголт, төлбөртэй холбоотой мэдээллийг цахим мэдээллийн санд бүрэн оруулаагүй, нэгж талбарын хувийн хэргийг журмын дагуу хөтлөөгүй байна.

Газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын хяналтын үнэлгээний мониторингийн сүлжээ, газрын биржийн болон газрын үнэлгээ, төлбөр, татвар, хураамж, газрын кадастрын бүртгэлийн цахим систем бүхий газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор батлан мөрдөж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.4 “*газрын мэдээллийн санг эрхлэх*” гэсэн заалтын дагуу Хатгал тосгоны газрын даамал эрхэлж газрын төлөвлөлт, олголт, эрх шилжүүлэг, олголт, татвар төлбөр, хураамж зэрэг мэдээллийг газрын цахим санд мэдээлж байна.

Хатгал тосгоны нийт 2506 нэгж талбарын цахим санд оруулсан мэдээллийг түүвэрлэн хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүснэгт №3

№	Мэдээллийн төрөл	Цахим санд мэдээлсэн байдал
1	Гэрээний төлөв	Цахим санд гэрээний төлөв тодорхойгүй 768 нэгж талбар байна.
2	Газрын зориулалт	Гэр орон сууцны зориулалтаар эзэмшсэн 54 газрыг тариалангийн зориулалттай гэж мэдээлсэн.
3	Улсын бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлийн Э-дугаарын мэдээлэл дутуу 1411 нэгж талбар

Дээрх зөрчил нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам”-ын 7.1.1 “*Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, тогтоомжид заасны дагуу газар зохион байгуулалтын дэс дараалсан үйл ажиллагааг аймаг, нийслэл дүүргийн Газрын алба, сумын газрын даамал эрхэлнэ*” гэсэн заалттай нийцэхгүй ба иргэд газар зохион байгуулалтын цахим мэдээллийн сангаас үнэн зөв мэдээлэл авах боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

Мөн нэгж талбарын хувийн хэргийг хөтлөхдөө эрх бүхий байгууллагаас баталсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй, хувийн хэргийн товьёг үйлдээгүй байна. Энэ нь Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын 2016 оны А/169 дүгээр тушаалаар баталсан “Нэгж талбарын хувийн хэргийг хөтлөх журам”-ын 2.2 “*Нэгж талбарын хувийн хэргийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан архивын стандарт хангасан А4 форматтай хавтсанд нэгж талбар тус бүрээр хавтаслана*”, 2.5 “*Нэгж талбарын хувийн хэрэгт хавсаргах баримт бичгүүдийг хавтаст байрлуулахдаа нотлох баримтын жагсаалт дахь дугаараар нь дэс дараалуулан хийнэ*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.1.3. Иргэн, хуулийн этгээдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаагүй байна.

Газрын тухай хуулийн дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0.07 га-аас илүүгүй газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлж байна.

Хатгал тосгонд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2022 онд 92 нэгж талбар, 2023 онд 53 нэгж талбарын газрыг олгосон ба түүнийг зориулалтын дагуу, үр нөлөөтэй ашиглаж байгаа эсэхийг хянаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №4

№	Газар олгосон шийдвэрийн нэр дугаар	Нийт олгосон газрын талбай		Зориулалтын дагуу ашиглаагүй газрын мэдээлэл		Хувь
		Тоо	Талбайн хэмжээ	Тоо	Талбайн хэмжээ	
1	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны 02 сарын 14-ний А/26 дугаар захирамж	59	40,620 м2	24	16,780 м2	40.8
2	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/156 дугаар захирамж	33	23,100 м2	20	14,000 м2	60.6
3	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны А/161 дүгээр захирамж	53	37,100 м2	26	18,200 м2	49.0
	НИЙТ	145	100,820 м2	70	48,980 м2	48.5

Хатгал тосгонд 2022 онд олгосон 92 нэгж талбараас 44 нэгж талбарыг буюу 48.9 хувийг 2023 онд олгосон 53 нэгж талбараас 26 нэгж талбарыг буюу 49.0 хувийг огт ашиглаагүй байна.

Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/26 дугаар захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон 59 иргэнээс 24 иргэн огт ашиглаагүй, 2022 оны А/156 дугаар захирамжаар олгосон 33 иргэнээс 20 иргэн огт ашиглаагүй байдалтай байна. Энэ нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн "40.1.6. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хүснэгт №5

№	Газар эзэмшүүлсэн он	Нийт олгосон газар	Үүнээс эрх шилжүүлсэн нэгж талбар	Хувь
1	2022	92	30	32.6
2	2023	53	1	1.9
	НИЙТ	145	31	21.4

Хатгал тосгонд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2022 онд нийт 92 газар олгосноос 30 иргэн буюу 32.6 хувь нь, 2023 онд гэр бүлийн хэрэгцээний

зориулалтаар 53 газар олгосноос 1 иргэн буюу 1.9 хувь нь газар эзэмших эрхээ тус тус шилжүүлсэн байна.

Хатгал тосгоны сүүлийн 3 жилийн газар олголтын байдлыг авч үзэхэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаж эхлээгүй, нийт олгосон газрын 21.4 хувийг эрх шилжүүлсэн байгаагаас харахад газар олголтын байдал үр нөлөөгүй байгаа нь харагдаж байна.

2.2. Газрын төлбөрийн орлогыг бүрэн ногдуулахгүй байгаагаас 29.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

2.2.1 Газрын төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөдөггүй, орлогыг бүрэн ногдуулахгүй байгаагаас 29.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Газрын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа, Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ногдуулна” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор газрын төлбөрийн хэмжээг тогтоосон байна.

Хатгал тосгоны газрын төлбөрийн орлого нь Алаг-Эрдэнэ суманд төвлөрч байна.

Алаг-Эрдэнэ сумын сүүлийн 3 жилийн газрын төлбөрийн орлогыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №6

№	Тайлант он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үүнээс Хатгал тосгоны газрын төлбөр	Хувь
1	2022	21.4	27.1	8.4	127%
2	2023	32.7	119.3	16.7	364.8%
3	2024 оны III улирал	37.8	51.5	14.0	136.2%
	НИЙТ	91.9	197.9	39.1	215.3

Алаг-Эрдэнэ сум нь газрын төлбөрийн орлогыг 2022 онд 127 хувиар, 2023 онд 364.8 хувиар, 2024 оны III улирлын байдлаар 136.2 хувиар тус тус биелүүлсэн байна.

Хатгал тосгоны газрын төлбөрийн орлогыг нийт нэгж талбарт үндэслэн тооцож үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №7

№	Тайлант он	Төвлөрүүлэх боломжит орлогыг аудитаар тооцоход	Төвлөрүүлсэн орлого	Зөрүү
1	2022	15.0	8.4	6.6
2	2023	29.4	16.7	12.7
3	2024 оны III улирал	24.4	14.0	10.4
	НИЙТ	68.8	39.1	29.7

Хатгал тосгоны газрын төлбөрийн төвлөрүүлэх боломжит орлогыг нэгж талбарын мэдээлэл, аймгийн ИТХ-ын 2022 оны 9 дүгээр тогтоолын гуравдугаар тогтоолоор баталсан газрын төлбөрийн хэмжээнд үндэслэн тооцож

үзэхэд 2022 онд 6.6 сая төгрөг, 2023 онд 12.7 сая төгрөг, 2024 онд 10.4 сая төгрөг төвлөрүүлэх боломжийг тус тус алдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Газрын тухай хуулийн 23.4.5. “газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Алаг-Эрдэнэ сумын газрын төлбөрийн орлого нь 2022 онд 127 хувиар, 2023 онд 364.8 хувиар тус тус биелсэн, мөн төсөв батлах үедээ Хатгал тосгоноос орлогын төлөвлөгөөний санал авдаггүй, 2022-2024 онуудад Хатгал тосгоны орлогоос 29.7 сая төгрөгийн орлогыг оруулах боломжтой байсан зэрэг нь газрын төлбөрийн орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөдөггүй, хяналт хангалтгүй байгаагаас орлого бүрэн төвлөрдөггүйг харуулж байна.

2.2.2 Алаг-Эрдэнэ сумын ИТХ-аас Хатгал тосгоны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн байна.

Газрын тухай хуулийн дагуу хяналтын чиг үүргийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

	Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавих
	Газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор 2010-2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах ажлын хэсгийг байгуулсан байна. Тус ажлын хэсгийн хийсэн хяналтаар газар олголт, ашиглалттай холбоотой 21 зөрчилтэй асуудлыг илрүүлж сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулсан боловч илэрсэн зөрчлийг арилгах талаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянаагүй байна.

Хатгал тосгоны Захирагч газар эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүд газрыг хууль тогтоомж, гэрээний дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавихаар ажлын хэсэг байгуулсан боловч хууль, эрх зүйн хувьд газар зохион байгуулалтын талаарх эрх хэмжээг тодорхой заагаагүй тул үр дүн хангалтгүй байна.

Аудитын явцад газар эзэмшиж байгаа иргэн, ашиглаж байгаа иргэд газрын гэрээ, кадастрын зурагт заасан хэмжээнээс илүү хэмжээгээр хашаалах, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшсэн газрын худалдаа үйлчилгээний зориулалтаар ашигласан зөрчлүүд гарч байна. Газар олголттой холбоотой зөрчлүүдээс дурдвал:

1. Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны А/161 захирамжаар олгогдсон 6714003635, 6714003634, 6714003406 гэсэн нэгж талбарын дугаар бүхий 3 газарт хэмжилт хийхэд 700 м²-аас хэтрүүлэн хашааг барьсан,
2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон 6714003972 нэгж талбар бүхий газарт Леона амралтын газрын үйлчилгээ үзүүлж байна,
3. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон 6714300353 нэгж талбарт худалдаа, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна,
4. Худалдаа нийтийн үйлчилгээний зориулалтаар олгосон 6714002375 нэгж талбарыг газар ашиглах гэрээ, гэрчилгээ, кадастрын зурагт заасан хэмжээнээс илүү хэмжээгээр, мөн усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зөрчиж хашаалсан байна.
5. Худалдаа, нийтийн үйлчилгээний газрын зориулалтаар олгосон 6714001378 дугаар бүхий газар нь кадастрын зурагт заасан хэмжээнээс илүү хэмжээгээр хашаалсан байна.

Алаг-Эрдэнэ сумын Засаг даргаас хийсэн хяналт хангалтгүй, тодорхой зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байгаа нь Газрын тухай хуулийн 20.2.2 “Газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул хяналтаа сайжруулж, илэрсэн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2024 онд газар эзэмшигч ашиглагчийн хувийн хэрэг, газрын нэгдсэн системд дотоод хяналт хэрэгжүүлсэн гэх боловч ирүүлсэн тайлан мэдээ, зөвлөмж байхгүй байна.

2.2.3. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт 80 хувьтай байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь газрын тухай хуульд нийцсэн эсэх” нийцлийн аудитыг хийж, 2022 онд тус аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах ажлыг гүйцэтгэсэн байна. Тус хяналтаар Хатгал тосгоны газар зохион байгуулалттай холбоотой 4 албан шаардлага, 11 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

Хүснэгт №8

Аудитын шийдвэрийн төрөл	Өмнөх аудит	Биелэлт	Хувь
	Тоо	Тоо	
Албан шаардлага	4	3	75
Зөвлөмж	11	9	81
Нийт дүн	15	12	80

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэхэд 1 албан шаардлага болон 2

зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Хэрэгжээгүй зөвлөмж, албан шаардлагыг авч үзвэл:

Хүснэгт №9

№	Хариуцах албан тушаалтан	Аудитын шийдвэрийн утга	Хэрэгжилт	Хувь
1	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны газрын даамал	Албан шаардлага: Хатгал Тосгонд газар эзэмшиж буй иргэн, аж ахуй нэгжид тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд нийт 14-н нэгж талбарт Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар 2019-он, 2020 он, 2021 он 2022 онуудад нийт 1.9 га буюу 19185 м.кв газрыг нэмэгдүүлэн эзэмшүүлсэн байна. Талбайн хэмжээг нэмэгдүүлсэн төлбөрийг нөхөн төлүүлэх	7 иргэн, ААН-ээс 7,209,080 төгрөгийг тушаалгаж, үлдсэн иргэдийг төлүүлэх талаар ажиллаж байгаа. 2023 оноос эзэмшиж байгаа талбайн хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд төлбөрийг авч байгаа.	50
2	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны газрын даамал	Зөвлөмж: Газар эзэмшигч, ашиглагч нь газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах.	Хатгал тосгоны захирагч газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ажиглаж, өмчилж байгаа эсэхэд хяналт тавих ажлын хэсэг байгуулсан боловч хууль эрх зүйн талаас хязгаарлагдмал байсан. Аудитаар илэрсэн зарим зөрчил нь хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалж байгаа тул хэрэгжилт хангалтгүй гэж үзлээ.	40
3	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны газрын даамал	Зөвлөмж: Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох, шилжүүлэх үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах.	Сумын ИТХ, Засаг дарга, даамал нар ажлын уялдаатай ажилласан боловч ИТХ-аас зохион байгуулсан шалгалтын үр дүн, зөвлөмж, албан даалгаврыг танилцуулаагүй байна	50

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд 80 хувьтай байна. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1-ээр оруулав.

Сумын ИТХ-аас хийсэн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, сумын Засаг дарга, газрын даамлаас хийх хяналт хангалтгүй байгаагаас зөрчил давтагдсаар байна.

Аудитаар нийт 29.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба 3 албан шаардлага, 10 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хөвсгөл аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд сумдын газар зохион байгуулалтыг хэт ерөнхий байдлаар тусгасан, нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө байхгүй нь газар зохион байгуулалтыг үр дүнтэй төлөвлөх боломжийг бууруулж байна.
2. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг хийхдээ иргэн аж ахуйн нэгжээс санал авахгүйгээр боловсруулсан, төлөвлөлтийн нэгж талбарын дугаарыг тавихгүйгээр баталсан нь газрын зориулалт, нэгж талбарын байршил солигдох, талбайн хэмжээ өөрчлөгдөх зэрэг эрсдэлийг дагуулж байна.
3. Хатгал тосгоны сүүлийн 3 жилийн газар олголтын байдлыг авч үзэхэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын 50 хувийг ашиглаж эхлээгүй, нийт олгосон газрын 21.4 хувийг эрх шилжүүлсэн байгаагаас харахад газар олголтын байдал үр нөлөөгүй байна.
4. Алаг-Эрдэнэ сумын газрын төлбөрийн орлого нь 2022 онд 127 хувиар, 2023 онд 364.8 хувиар тус тус биелсэн, мөн төсөв батлах үедээ Хатгал тосгоноос орлогын төлөвлөгөөний санал авдаггүй, 2022-2024 онуудад Хатгал тосгоны орлогоос 29.7 сая төгрөгийн орлогыг оруулах боломжтой байсан зэрэг нь газрын төлбөрийн орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөдөггүй, хяналт хангалтгүй байгаагаас орлого бүрэн төвлөрдөггүйг харуулж байна.
5. Сумын ИТХ-аас хийсэн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, сумын Засаг дарга, газрын даамлаас хийх хяналт хангалтгүй байгаагаас зөрчил давтагдан гарч байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамруулан шинэчилж боловсруулан, батлуулах

Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Жанлав:

1. Хатгал тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчилж батлах
2. Сумын ИТХ-аас хийсэн хяналтын тайланг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, хэрэгжилтийг тооцож ажиллах

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Ганзоригт:

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд сум, тосгоны газар зохион байгуулалтыг бүхэлд хамруулж боловсруулах

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга З.Ням-Очир, Хатгал тосгоны захирагч А.Баттүшиг нарт:

1. Хатгал тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчилж боловсруулах
2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалт хийх” журмыг мөрдөж ажиллах
3. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг төлөвлөлтийн нэгж талбарын дугаараар батлуулах

Сумдын Засаг дарга нарт:

1. Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчилж боловсруулах

Хатгал тосгоны газрын даамал Ч.Оюунгэрэлд:

1. Газрын цахим мэдээллийн санд нэгж талбарын мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулах
2. Нэгж талбарын хувийн хэргийг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу бүрдүүлж, хөтлөх

Холбогдох байгууллагын санал:

Санал ирүүлсэн байгууллага	Санал	Санал шийдвэрлэсэн байдал
Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА ЗДТГ-ын байр, Алаг-Эрдэнэ сум, Хөвсгөл аймаг, 67140 Утас: 98850052 Факс: . Цахим шуудан: aerdenezdtg@khs.gov.mn Цахим хуудас: http://alag-erdene.khs.gov.mn 2024.11.05 № 01/306 танай _____-ны № _____-т 「 ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлд оруулах тайлбар, санал байхгүй болно.  Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын засаг даргын тамгын газар Удирдлага Сумын засаг дарга Загдсамбар Нямочир 2024-11-05 09:42:25	Санал ирүүлээгүй байна.

Хатгал тосгоны захирагч	 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ Захирагчийн ажлын албаны байр, Хатгал тосгон, Хөвсгөл аймаг, 67340, Утас: 92113504 Цахим шуудан: hatgalzdg@khs.gov.mn Цахим хуудас: www.khatgal.khs.gov.mn 2024.11.04 № 1/512 танай 2024.11.04 -ны № 1/889 -т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Хатгал тосгоны газар зохион байгуулалт, газар олголтын байдал, үр нөлөө гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлд оруулах санал байхгүй болно.  6734001095	Санал ирүүлээгүй байна.
-------------------------	--	-------------------------

Зөрчлийн нэгтгэл:

/Сая.төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аудитаар аймаг, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний судалгааг авч үзэхэд Хөвсгөл аймгийн хувьд Ханх, Цэцэрлэг, Рашаант, Түнэл, Мөрөн сумаас бусад сумд нь төлөвлөгөөгүй байна. Үүнээс шалтгаалан 2024 онд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг системд оруулаагүйгээс шинээр газар олгох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.	0			2	
2	Хатгал тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа талбар дээр хангалттай ажиллаагүй, нутгийн удирдлага, газрын даамалтай нарийвчлан зөвшилцөөгүй, мөн Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулаагүй боловсруулсан байна	0			2	
3	Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Хатгал тосгоны эдэлбэр газрын газар зохион байгуулалтыг хэт ерөнхий байдлаар тусгасан, нийт талбайг бүхэлд нь хамруулаагүйгээс Хатгал тосгоны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний суурь болж чадахгүй байна.	0			1	
4	Хатгал тосгоны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа иргэн, аж ахуйн нэгжийн саналыг аваагүй байна.	0			1	
5	Хатгал тосгоны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд газрын зориулалтыг тусгасан боловч төлөвлөлтийн нэгж талбарын дугаарыг тавиагүй байна.				1	
6	Газрын цахим мэдээллийн сангийн мэдээлэл хангалтгүй байна.	0			1	
7	нэгж талбарын хувийн хэргийг хөтлөхдөө эрх бүхий байгууллагаас баталсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй, хувийн хэргийн товьёг үйлдээгүй байна.	0			1	
8	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны А/26 дугаар захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон 59 иргэнээс 24 иргэн огт ашиглаагүй, 2022 оны А/156 дугаар захирамжаар олгосон 33 иргэнээс 21 иргэн огт ашиглаагүй байдалтай байна.	0	1	0		
9	Хатгал тосгоны газрын төлбөрийн төвлөрүүлэх боломжит орлогыг нэгж талбарын мэдээлэл, аймгийн ИТХ-ын 2022 оны 9 дүгээр тогтоолын гуравдугаар тогтоолоор баталсан газрын төлбөрийн хэмжээнд үндэслэн тооцож үзэхэд 2022 онд 6.6 сая төгрөг, 2023 онд 10.4 сая төгрөг, 2024 онд 10.4 сая төгрөг төвлөрүүлэх боломжийг тус тус алдсан байна.	29.7	1	29.7		

10	Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор 2010-2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах ажлын хэсгийг байгуулсан байна. Тус ажлын хэсгийн хийсэн хяналтаар газар олголт, ашиглалттай холбоотой 21 зөрчилтэй асуудлыг илрүүлж сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулсан боловч илэрсэн зөрчлийг арилгах талаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянаагүй байна.				1	
10	Алаг-Эрдэнэ сумын Засаг даргаас хийсэн хяналт хангалтгүй, тодорхой зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.		1			
ДҮН		29.7	3	29.7	10	0

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ:

№	Хариуцах албан тушаалтан	Аудитын шийдвэрийн утга	Шийдвэрийн хэрэгжилт	Биелэлтийн хувь
1	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны газрын даамал	Албан шаардлага: Хатгал Тосгонд газар эзэмшиж буй иргэний хувийн хэргийг түүвэрлэн үзэхэд 7 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчинтэй хэвээр байхад тухайн нэгж талбарын мэдээлэл нь газрын мэдээллийн нэгдсэн санд байхгүй, мөн нэгж талбарын байршлыг тулгаж үзэх кадастрын зураг байгаа зөрчлийг арилгах	7 иргэний мэдээллийг системд оруулж зөрчилгүй болсон байна.	100
2	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны газрын даамал	Албан шаардлага: Хатгал Тосгонд газар эзэмшиж буй иргэн, аж ахуй нэгжид тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд нийт 14-н нэгж талбарт Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар 2019- он, 2020 он, 2021 он 2022 онуудад нийт 1.9 га буюу 19185 м.кв газрыг нэмэгдүүлэн эзэмшүүлсэн байна. Талбайн хэмжээг нэмэгдүүлсэн төлбөрийг нөхөн төлүүлэх	7 иргэн, ААН-ээс 7,209,080 төгрөгийг тушаалгаж, үлдсэн иргэдийг төлүүлэх талаар ажиллаж байгаа. 2023 оноос эзэмшиж байгаа талбайн хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд төлбөрийг авч байгаа.	50
3	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал тосгоны газрын даамал	Албан шаардлага: Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/59 захирамжаар 6714003041 дугаартай нэгж талбарт ХҮ-ий зориулалтаар ашиглахдаа гэрээ, кадастрын зурагт заасан хэмжээнээс илүү хэмжээгээр усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зөрчиж хашаалсан зөрчлийг арилгах	Хатгал тосгоны захирагчийн 2023 оны 5 сарын 01-ний 1/239 албан тоотоор усан сан бүхий хамгаалалтын бүс зөрчсөн хашааг албадан чөлөөлөх мэдэгдлийг иргэн Ц.Мөнгөнцэцэгт хүргүүлж тохиролцсон байна.	100
4	Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга, Хатгал газрын даамал	Албан шаардлага: Хатгал Тосгоны эдэлбэр газар дахь Хөвсгөл нуурын эрэг орчмын усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс, энгийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлээгүй байна	Нуурын эрэг орчмын усан сан бүхий газрын онцгой хамгаалалттай бүс, энгийн болон эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлж 8 самбар байршуулсан	100
5	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон түүнд нийцүүлэн боловсруулсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэхгүй байх.	2023-2024 онуудад төлөвлөгөөнд тусгаагүй байршилд газар эзэмшүүлээгүй байна.	100
6	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх шийдвэрт тухайн газрын зориулалт, тайлбарыг тодорхой тусгах	Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх шийдвэрт тухайн газрын зориулалт, тайлбарыг тусгаж байгаа	100

7	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэхдээ хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх	Иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэхдээ хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон тохиолдолд хэтэрсэн хэмжээнд төлбөр авч байгаа	100
8	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Иргэн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу үнэ төлбөргүй газар эзэмшүүлэхээс бусад тохиолдолд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулж байх	Иргэн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу үнэ төлбөргүй газар эзэмшүүлэхээс бусад тохиолдолд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулж байгаа	100
9	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн газраас иргэн, хуулийн этгээдэд шилжүүлсэн байна	Дуудлага 4 айлын орон сууцыг дуудлага худалдаагаар худалдсантай холбоотой газрыг нь цуг шилжүүлсэн. Өөр тохиолдолд шилжүүлээгүй.	100
10	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэхдээ гэрээ зөрчилтэй бол зөрчлийг арилгахгүй байна	Зөрчилтэй газрыг бусдад шилжүүлээгүй	100
11	Сумын Засаг дарга	Иргэн, хуулийн этгээдэд шинээр газар эзэмшүүлэхдээ ойн болон усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зөрчихгүй байх	Сүүлийн жилүүдэд ойн болон усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зөрчиж газар олгоогүй	100
12	Сумын Засаг дарга	Зөвлөмж: Газар эзэмшигч, ашиглагч нь газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих	Хатгал тосгоны захирагч газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ажиглаж, өмчилж байгаа эсэхэд хяналт тавих ажлын хэсэг байгуулсан боловч хууль эрх зүйн талаас хязгаарлагдмал байсан	50
13	Сумын ИТХ	Зөвлөмж: Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох, шилжүүлэх үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангаж ажиллах	Сумын ИТХ, Засаг дарга, даамал нар ажлын уялдаатай ажилласан боловч ИТХ-аас зохион байгуулсан шалгалтын үр дүн, зөвлөмж, албан даалгаврыг танилцуулаагүй байна.	50
14	Сумын ИТХ	Зөвлөмж: Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих	2021-2022 онуудад газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй холбоотой зөрчил гараагүй	100
15	Сумын ИТХ	Зөвлөмж: Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих	Сумын ИТХ-аас тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд 2010-2023 оныг хамруулан хяналт хэрэгжүүлсэн	100